

**“НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХИЙГ
БЭХЖҮҮЛЭХ НЬ” ХӨТӨЛБӨР**

Хөтөлбөрийн зорилго:

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь Үндсэн хууль болон бусад хуулинд заасан эрхээ хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн зохион байгуулах чадамжийг дээшлүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт:

1. Аймаг сумын ИТХ-ын Ажлын албыг бэхжүүлэх, арга зүйн удирдлагаар хангах
2. Хүний нөөцийн хөгжлийг дэмжих
3. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хяналт шалгалт

Нутгийн өөрөө удирдах байгууллага үйл ажиллагаандаа дараахь зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

1. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэнэ.
2. Тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн ашиг сонирхолыг илэрхийлнэ
3. Тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлно.
4. Түүхэн уламжлал, зан заншил, хүн амын бодлого, эдийн засаг, газар зүйн онцлогийг харгалзан асуудлыг шийдвэрлэнэ.
5. Тухайн нутаг дэвсгэрийнхээ хүн амын өмнө ажлаа тайлагнаж, хариуцлага хүлээнэ.

6. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, асуудлыг ил тод, ардчилалын зарчимд тулгуурлан шийдвэрлэнэ.

Хамрах хүрээ:

Аймаг, сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар, Хурлын хороод, Намын бүлгүүд, Хурлын дэргэдэх болон харъяа байгууллагууд, Ажлын албаны ажилтнууд

Хугацаа:

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны Нутгийн удирдлага хуулийн хэлтэс. 2014 онд

Хүрэх үр дүн:

1. Орон нутгийн Өөрөө удирдах байгууллагын шийдвэрт иргэдийн санаа бодлыг тусгах боломж бүрдэнэ.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын хүний нөөцийн чадавх дээшлэнэ.
3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын хариуцлага, сахилга сайжирч, эрх зүй боловсронгуй болно.

НЭГ. Аймаг сумын ИТХ-ын Ажлын албыг бэхжүүлэх, арга зүйн удирдлагаар хангах

Энэ бүлэг нь:

“Ажлын албаны гүйцэтгэх үүрэг, чиглэлийг боловсронгуй болгох нь”

“Нутгийн захиргааны болон Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа” гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ.

1.1. Ажлын албаны гүйцэтгэх үүрэг, чиглэлийг боловсронгуй болгох нь:

а/ Нарийн бичгийн дарга нар, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж, оновчтой болгоно

б/ Хурлын дэргэдэх байгууллагууд: Хороод, намын бүлгүүд, ажлын хэсэг, түр хороодын ажлын төлөвлөгөө, хяналтын чиг үүргийг тодорхой гарган жилийн төлөвлөгөөтэй ажиллуулна.

в/ Ажил дүгнэх журмыг боловсронгуй болгож, ажлын албаны тайлагналтыг ил тод, нээлттэй болгож, жил бүр иргэд болон төлөөлөгчдөд тайлагнах механизмийг боловсронгуй болгоно.

г/ Ажлын албаны авууштай туршлагыг түгээн дэлгэрүүлж, харилцан суралцах боломжийг судалж, сургалт, арга зүйн тодорхой төлөвлөгөөтэй ажиллана.

1.2. Нутгийн захиргааны болон Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа:

а/ Сонирхлын зөрчил, жендерийн ойлголт, хүний эрхийн суурь ойлголтуудын талаар сургалтыг зохион байгуулах

б/ Удирдлагын манлайлал, харилцааны асуудлаар тусгай хөтөлбөрөөр сургалтын байгууллагад захиалга өгч сургалтанд хамруулна.

ХОЁР. Хүний нөөцийн хөгжлийг дэмжих

2.1. Идэвхтэн сонгуультныг чадавхжуулах

а/ Бүсийн болон орон нутгийн сургалтын хөтөлбөр

б/ Удирдлагын академийн модульт сургалтуудад хамруулах хөтөлбөр

в/ Туршлага судлуулах, хамтран ажиллах хөтөлбөр

2.2. Хурлын дарга, нарийн бичгийн дарга, ажилтнуудыг чадавхжуулах

а/ Бүсийн болон орон нутгийн сургалтын хөтөлбөр

б/ Удирдлагын академийн модульт сургалтуудад хамруулах хөтөлбөр

в/ Туршлага судлуулах, хамтран ажиллах хөтөлбөр

г/ Иргэдэд ажлаа тайлагнах, тэдний санал бодлыг тусгах үйл ажиллагаандаа оролцуулах хөтөлбөр

2.3. “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалт, бүсийн уулзалт, хурал зөвлөгөөний төлөвлөгөө

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс сэдвээр сургалтын хэрэгцээ				
1.1. Нутгийн өөрөө удирдлагын тухай ойлголт	МНУ Холбоотой хамтрах	2014.04.28- 05-р сар	2 цаг	Сумын хурлын дарга, нарийн бичгийн дарга нарт
1.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөллийн үүрэг			2 цаг	
1.3. Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын эрх, үүргийг тодорхойлсон гол хуулиуд, тэдгээрийг хурлын үйл ажиллагаанд хэрхэн ашиглах, хуулийн хүрээнд шийдвэр гаргах нь			2 цаг	
1.4. Иргэдийн төлөөлөгчдийн хурал ба засаг даргын харилцааны асуудал, засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих арга замууд асуулга, асуулт тавих журмууд			2 цаг	
2. Өмчийн харилцааг боловсронгуй болгох чиглэлээр сургалтын хэрэгцээ				
3.1. Төсвийн тухай ерөнхий ойлголт	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр		1 цаг	Аймаг сумын ИТХ-ын төлөөлөгчид, эдийн засаг, төсвийн хорооны гишүүд, нарийн бичгийн дарга нар, нягтлан бодогч нар
3.2. Төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх шатуудад хурлын төлөөлөгчийн үүрэг			1 цаг	
<ul style="list-style-type: none"> Урт хугацааны хөгжлийн төлөвлөлт Хөрөнгө оруулалтын төлөвлөлт 			1 цаг	
<ul style="list-style-type: none"> Төсөв боловсруулах Төсвийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа Хөрөнгө нөөцийн ашиглалт Санхүүгийн тайлан Дотоод хяналт, мониторинг Үнэлгээ, аудит Орон нутгийн өмчийн талаар хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлон зохион байгуулах нь 	УИХ-ын төрийн байгуулалтын болон төсвийн байнгын хороотой хамтран	1. 2014 оны 03 дугаар сар	1 цаг	Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид, нарийн бичгийн дарга нар, эдийн засаг, төсвийн хорооны гишүүд, болон нягтлан бодогч нарт
			1 цаг	
			1 цаг	
			1 цаг	
			1 цаг	
			1 цаг	
			1 цаг	
3. Хэлэлцүүлэг явуулах, Мэдээллээр хангах хэрэгцээ				
3.1. Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар нутгийн удирдлагын эрх, үүрэг	ЗДТГ, БОГ	2014 оны 05	1 цаг	Иргэний танхимын ажилтнууд, олон нийтийн байцаагч
3.2. Байгалийн нөөцийн			1 цаг	

менежментийн төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтэд хяналт тавих	ИТХ	сар		нар, иргэний нийгмийн байгууллага
3.3.Байгалийн нөөцийн хамтын менежментийн зарчим			1 цаг	
3.4.Ногоон хөгжлийн үзэл санаа, зарчим, стратеги, Хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлого тодорхойлон хэрэгжүүлэх			1 цаг	
4. Туршлага судлах арга хэмжээ	МНУХ	2014.07 сар		Аймаг сумын ИТХ-ын ажлын алба , төлөөлөгчид
5. Тайлагналт	Аймгийн ИТХ-ын НУХХэлтэс	2014.12 сар	17 сум	Сумын ИТХ-ын Ажлын алба
4. Хяналт шалгалт, төлөөлөгчид иргэдийн уулзалт				
6. Бүсийн сургалт, уулзалт	Баруун бүсийн 5 аймаг	2014.10 Сард	Говь-Алтай аймгийн ИТХ	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид Ажлын алба
7. Модульт сургалт	Удирдлагын академи	2014.09 сард	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид
8. Тэргүүлэгчдийн хурал	Баруун 3 сум, Цэцэг, Мөст сум -Булган суманд	2014 оны 04 сард	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Тэргүүлэгчид
9. Тэргүүлэгчдийн хурал	Зүүн сумууд: Манхан , Зэрэг, Дарви, Чандмань, Дуут, Мөнххайрхан сумууд- Зэрэг суманд	2014 оны 04 сард	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид Тэргүүлэгчид
10.Тэргүүлэгчдийн хурал	Дөргөн, Мянгад Ховд , Эрдэнэбүрэн сумууд- Мянгад суманд	2014 оны 10 сард	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Тэргүүлэгчид
11.Хороодын хяналт шалгалт, иргэдтэй хийх уулзалт /сум бүрт тусгай хөтөлбөр гаргана/	Алтай, Булган Үенч, Эрдэнэбүрэн, Ховд, Дөргөн, Мянгад, Буянт	2014 оны 2-3 дугаар улиралд	Ажлын алба зохион байгуулна	Аймаг ,сумын ИТХ-ын төлөөлөгчид, хороод

ГУРАВ. САНХҮҮЖИЛТ

Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн зардал.

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХЯНАЛТ

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нэг гол үүрэг нь хяналт шалгалтын ажил мөн. ИТХ нь нутаг дэвсгэртээ өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хянахаас гадна УИХ-ын батлан гаргасан хуулиудын хэрэгжилт, Монгол улсын Ерөнхийлөгчийн албан даалгавар, зөвлөмж, Засгийн газрын тогтоолуудын хэрэгжилтийг зохион байгуулах, хянах шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах явдал байдаг.

3.1.Төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалт, үр дүнд тавих хяналт

ИТХ-ын хяналтын гол хэсэг нь төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хуваарилалт, түүний үр дүнгийн байдалд тавих хяналт юм. ИТХ-ын хуралдаанаар батлагдсан Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, өр авлагын шийдэл, орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, түүний зарцуулалтын байдалд нийт иргэдийн арх ашгийн өмнөөс хяналт тавина. /сум бүр тусгай төлөвлөгөөгөөр/

3.2. Хурлын шийдвэрийг иргэдэд хүргэх ажиллагаа, хэрэгжилтэнд хяналт тавих

ИТХ-ын шийдвэрийн хэрэгжилтэнд тавих аливаа хяналт нь юуны түрүүнд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага руу чиглэх бөгөөд Засаг дарга, түүний Тамгын газар, харъяа болон дэргэдэх газар, хэлтэс, агентлагийн дарга нарын илтгэл, сонсгол мэдээллийг авч хэлэлцэх, ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх, ИТХ-ын хороо хэсгээс болон мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан хяналт шалгалтын баг, ажлын хэсэг гарган ажиллуулах зэргээр Хурлын шийдвэрийн гүйцэтгэлийг хянана.

ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

1. Аймгийн ИТХ-ын Ажлын алба, Нутгийн удирдлага хуулийн хэлтэс
2. Сумын ИТХ-ын Ажлын алба, Хурлын дэргэдэх байгууллага